

ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид компани гэх/-ийн төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад өвлүүлэх, бэлэглэх тухай журам” /цаашид хорооны журам гэх/, компанийн холбогдох журмуудыг удирдлага болгоно.

1.3 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэхтэй холбогдсон үйлчилгээг компанийн Хадгаламж өмчлөх эрх бүртгэл, кастодианы алба /цаашид алба гэх/ хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Журмын нэр томъёо

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1 “үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.8-д зааснаар ойлгох;

2.1.2 “төвлөрсөн хадгаламж” гэж ҮЦТХТөвд биет болон биет бус үнэт цаасыг тоо ширхэг, хувьцаа эзэмшигчдийн нэр хаягаар нь тусгай бүртгэл хөтлөн хадгалах, биет бус үнэт цаасыг файл хэлбэрээр компьютерын санах байгууламжид бүртгэсэн цогц хадгаламж;

2.1.3 “данс” гэж Үнэт цаасны компаниар дамжуулан ҮЦТХТөвд нээлгэсэн үнэт цаасны данс, биржийн бус мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон төлбөр тооцоо хийх үүрэг бүхий данс;

2.1.4 “ХОЭБ” гэж хөрөнгө оруулалтын эрхийн бичиг;

2.1.5 “Т+3” гэж арилжаа хийгдсэнээс хойш 3 дах өдөрт өмчлөх эрх шилжүүлэх хугацаа;

2.1.6 “эрх бүхий байгууллага” үүнд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хууль хяналтын байгууллага;

2.1.7 “харилцагч” гэж компаниас үзүүлж буй үйлчилгээг авч байгаа Монгол улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол улсын болон гадаадын хуулийн этгээд;

2.1.8 “чөлөөт үлдэгдэл”/balance free/ гэж тухайн харилцагчийн дансан дахь үнэт цаасны эхний үлдэгдлээс худалдан авахаар болон худалдахаар хүлээгдэж буй үнэт цаасыг хассан үнэт цаасны тоо гэж ойлгох;

2.1.9 “Худалдан авахаар хүлээгдэж буй үнэт цаас” /pending buy/ гэж худалдан авах хэлцэл хийгдсэн боловч төлбөр тооцоо нь Т+3 өдөр хүртэл хүлээгдэж буй үнэт цаас

2.1.10 “Худалдахаар хүлээгдэж байгаа үнэт цаас” /pending sell/ гэж худалдах хэлцэл хийгдсэн боловч төлбөр тооцоог Т+3 өдөр хүртэл хийхийг хүлээж буй үнэт цаас

2.1.11 “тусгаарлах” /freeze/ гэж эрх бүхий байгууллага болон харилцагчийн хүсэлтээр харилцагчийн дансан дах үнэт цаасыг тодорхой хугацаагаар хөдөлгөөнгүй болгох

2.1.12 “чөлөөлөх” /release/ гэж эрх бүхий байгууллага болон харилцагчийн хүсэлтээр тусгаарлагдсан үнэт цаасыг сэргээх гэж ойлгох

Гурав. Төвлөрсөн хадгаламжид данс нээх, хаах, дансны гэрээ

3.1 Харилцагч нь Үнэт цаасны компани /цаашид ҮЦК гэх/-иар дамжуулан “Төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ”-ний дагуу /Маягт-1/ компанид данс нээлгэж, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх /цаашид өмчлөх эрх гэх/ болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэх, ХК-иас хэрэгжүүлж буй үйлчилгээг авна.

3.2 Хувь хүн нь хэд хэдэн оролцогч дээр данс нээж болох ба нэг оролцогч дээр зөвхөн нэг данс нээлгэнэ. Хуулийн этгээд нь нэг болон түүнээс дээш тооны дансыг нэг болон хэд хэдэн оролцогчоор дамжуулан нээж болно.

3.3 Харилцагч данс нээлгэхдээ дор дурьдсан баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.3.1 иргэн бол данс нээх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар;

3.3.2 хуулийн этгээд бол данс нээлгэхийг хүссэн хүсэлт, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.3.3 хуулийн этгээдийн дансан дахь хөрөнгийг захиран зарцуулах этгээдийг томилсон тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.3.4 Гадаад улсын иргэн данс нээлгэх болон дансны мэдээлэлд өөрчлөлт оруулах бол данс нээх

гэрээ, гадаад паспортын хуулбар болон бусад холбогдох баримт бичиг;

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

3.3.5 Гадаад улсын хуулийн этгээд данс нээлгэх болон дансны мэдээлэлд өөрчлөлт оруулах бол данс нээх гэрээ, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар болон бусад холбогдох баримт бичиг; /дээрх баримт бичгүүдэд апостиль гэрчилгээ хийлгэсэн байна/

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

3.4 Данс нээх гэрээнд гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, хариуцлагыг заавал тусгасан байна.

3.5 Харилцагч төвлөрсөн хадгаламжийн дансыг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох, данс дахь үнэт цаасыг бусдад өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх, хандивлах эрхтэй.

3.6 Алба нь хууль тогтоомжид заасан шаардлага хангасан хүчин төгөлдөр итгэмжлэл, өв залгамжлалын гэрчилгээ, гэрээслэл, бэлэглэлийн гэрээг үндэслэн дээрх эрхийг эдлүүлнэ.

3.7 Алба нь ҮЦК-иас ирүүлсэн “Төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ” болон бусад баримтыг хүлээн авч хянан, ҮЦК-ийн мэдээлэл болон УБЕГ-аас ирүүлсэн мэдээллийн сантай тулган, тохирсон тохиолдолд ажлын гурав хоногт дансыг нээх буюу баримт бичгүүд шаардлага хангаагүй бол данс нээхээс татгалзах эрхтэй.

3.7.1 ҮЦК нь компанийн тусгай цахим системд холбогдож мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээнд “Цахим үйлчилгээ үзүүлэх гэрээ” /гэрээ-1/-г байгуулж данс нээх анхан шатны баримт дээрх мэдээллийг уг системээр дамжуулан илгээж болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

3.7.2 ҮЦК нь данс нээх анхан шатны баримтын мэдээллийг уг системээр дамжуулан зөвхөн файлаар илгээх бөгөөд харилцагчтай байгуулсан данс нээх гэрээ буюу анхан шатны баримтыг ҮЦК өөр дээрээ баримтжуулан хадгална.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

3.7.3 ҮЦК нь цахим системээр мэдээлэл илгээх, хүлээн авах өөрийн мэдээлэл технологийн чадавхитай байж, өөрийн системийн бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

3.7.4 Аль нэг тал нь цахим системээр данс нээх мэдээлэл илгээх боломжгүй болсон эсвэл хүлээн авах боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын 1 хоногийн дотор мэдэгдэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

3.8 ҮЦК-иас ирүүлсэн данс нээх гэрээний хавсралт баримт бичгүүд баримтын шаардлага хангаагүйгээс данс нээгдээгүй тохиолдолд буцаан өгөх ба энэ талаар гүйлгээ хариуцсан ажилтан ямар шалтгаанаар буцсан тухай тайлбарыг ҮЦК-д бичгээр өгнө.

3.9 Харилцагч “Төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ”-ний үзүүлэлтэнд өөрчлөлт орсон тухай бүр өөрийн харилцагч ҮЦК-д албан ёсоор мэдэгдэнэ.

3.10 Алба нь дараах тохиолдолд дансны гүйлгээг түр хугацаагаар зогсоож болох ба уг дансыг хаалгасан этгээдийн хүсэлтээр гүйлгээг сэргээнэ. Үүнд:

3.10.1 Харилцагч өөрийн эзэмшлийн дансны гүйлгээг түр хугацаагаар зогсоох болон сэргээх тухай хүсэлтээ бичгээр гаргасан;

3.10.2 Төвлөрсөн хадгаламж дахь дансны гүйлгээг түр хугацаагаар зогсоох болон сэргээх тухай СЗХ болон шүүх, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр бичгээр ирсэн;

3.10.3 Төвлөрсөн хадгаламж дахь дансны гүйлгээг данс эзэмшигчийн хүсэлтээр түр зогсоосон үед дансыг тусгаарлах эсхүл дансны гүйлгээг сэргээх, нээх, хэлцэл хүчингүй болсонтой холбогдуулан үнэт цаасыг данс хооронд шилжүүлэх тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд тухайн эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3.11 Алба нь гүйлгээтэй холбоотой мэдээллийг шүүх, цагдаагийн байгууллагын хүсэлтээр гаргаж өгнө.

3.12 Төвлөрсөн хадгаламжид нээлгэсэн харилцагчийн дансыг нэгтгэх гүйлгээг харилцагчийн зөвшөөрөл, ҮЦК-ийн хүсэлт, холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хийнэ.

3.13 Төвлөрсөн хадгаламж дахь харилцагчийн дансны мэдээлэл нэг үсэг, тооны зөрүүтэй байгаа тохиолдолд тухайн харилцагчийн хүсэлт эсхүл ҮЦК-ийн хүсэлт болон бичиг баримтын хуулбарыг үндэслэн өөрчлөлт оруулах, хэрэв тухайн дансны мэдээллийн зөрүү дээрхээс илүү байгаа тохиолдолд дээр дурдсан баримтаас гадна холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон лавлагааг үндэслэн өөрчлөлтийг оруулна.

3.14 “ХОЭБ-ээр эзэмшсэн хувьцааны данс нь гэр бүлийн гишүүдийн нэр дээрх дансанд шилжүүлэгчээр орж төвлөрсөн хадгаламжид бүртгэгдсэн харилцагч эзэмшлийн хувьцаагаа өөрийн нэр дээрх дансандаа шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн тохиолдолд компанийн дотоод хяналтаас анхан шатны баримт, арилжааны товчоо, мэдээллийн сантай тулгалт хийж эзэмшигч мөн болохыг нотолсны дагуу холбогдох залруулгыг хийж гүйцэтгэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 10 тоот тогтоолоор нэмэлт оруулсан/

Дөрөв. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэхэд тавигдах шаардлагууд

4.1 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн баримтын бүрдүүлбэр болон өмчлөх эрхийг шилжүүлэхэд тавигдах шаардлагыг компани тогтооно. Үүнд:

4.1.1 үнэт цаас нь тухайн хууль ёсны өмчлөгчийн өмч мөн эсэх;

4.1.2 тухайн өмчлөгчийн үнэт цаасанд үүрэг ногдуулсан бүртгэл хийгдсэн эсэх;

4.1.3 уг үнэт цаастай холбоотойгоор хуулийн байгууллагад өмчлөх эрхийн талаар маргаан үүссэн тухай компанид мэдэгдэл ирсэн эсэх;

4.2 Журмын 4.1-д заасан шаардлагуудыг гүйлгээ хариуцсан ажилтан шалгаж, шаардлага хангаж байгаа тохиолдолд гүйлгээг хийх ба 4.1.3-т заасан бүртгэл, мэдэгдэл эрх бүхий байгууллагаас ирж, тусгаарласан тохиолдолд тухайн шийдвэрийг гаргасан эрх бүхий ажилтан эсхүл удирдах албан тушаалтнаас шийдвэрийг хүчингүй болсон тухай мэдэгдэл ирэх хүртэл хугацаанд өмчлөх эрх шилжүүлэхийг хориглоно.

4.3 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх гүйлгээний баримтын үзүүлэлтүүд тодорхой, гаргацтай, бүрэн гүйцэд, засваргүй, тамга /тэмдэг/, гарын үсгээр баталгаажсан байна. Харилцагчийг төлөөлөн гүйлгээ хийлгэх тохиолдолд нотариатаар баталгаажсан итгэмжлэлийг үндэслэнэ.

4.4 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг энэхүү журмын дагуу шилжүүлэх тохиолдолд харилцагч нь төвлөрсөн хадгаламжид өөрийн нэр дээр урьдчилан данс нээлгэсэн байх шаардлагатай. Харилцагч нь журмын 5 дугаар бүлэгт заасан үйлчилгээг авахдаа холбогдох үйлчилгээний шимтгэлийг төлсөн төлбөрийн баримтыг ирүүлнэ.

4.5 Ажилтан баримтын бүрдэл дутуу болон зохих зөвшөөрөлгүй гүйлгээг хийх, баримтыг хуурамчаар бүрдүүлэх, нуун дарагдуулахыг хориглоно.

4.6 Алба нь баримт хүлээн авсан дэс дарааллыг баримтлан өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагааг цахим тооцоолуурын сүлжээний тусламжтайгаар гүйцэтгэнэ.

4.7 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх гүйлгээний баримтуудыг ҮЦК болон харилцагчдаас ажлын өдөр бүр 09.00-12.30, 14.00-17.00 цагийн хооронд тус тус хүлээн авч бүртгэл хөтөлнө.

Тав. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бусдад шилжсэнийг бүртгэх үйлчилгээ

5.1 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг төвлөрсөн хадгаламж дахь харилцагчийн дансны үлдэгдэл, өв залгамжлах эрхийн гэрчилгээ, бэлэглэлийн гэрээ, Сангийн яам (битүүмжилсэн болон дуудлага худалдаагаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжсэн) болон СЗХ (нэр зааж шинээр болон нэмж гаргасан үнэт цаас, өрийн хувьцаагаар солих)–ны шийдвэр, шүүхийн шийдвэр зэргийг үндэслэн хийж гүйцэтгэнэ.

5.2 Харилцагч нь төвлөрсөн хадгаламжийн дансан дахь үнэт цаасыг өв залгамжлалаар хүлээн авах тохиолдолд өв залгамжлах эрхийн гэрчилгээ, өвлөгчийн иргэний үнэмлэх, өвлөгчийн өргөдөл, гүйлгээний шимтгэл төлсөн баримт зэргийг үндэслэн гүйлгээ хийнэ. Өв нээгдсэн тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд өвлөгчид шилжих хүртэл хугацаагаар өвлүүлэгчийн данснаас гүйлгээ хийхийг хориглоно.

5.2.1 Харилцагч гадаад улсад хийгдсэн өв залгамжлал хүлээн авах тохиолдолд 5.2-т заасан баримтыг бүрдүүлж, тухайн улсын Элчингийн газар болон Консулын газраас баталгаажуулсан өв залгамжлах гэрчилгээний эх хувь буюу нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, монгол хэл дээр орчуулсан орчуулгын хамтаар ирүүлнэ.

5.3 Харилцагч нь өөрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээ бусдад бэлэглэх тохиолдолд

Хорооны журамд заасан баримтыг бүрдүүлж, гүйлгээний шимтгэл төлсөн төлбөрийн баримтыг ирүүлнэ.

5.4 Өмч хувьчлалын хүрээнд төр үнэт цаасаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын арилжаанаас гадуур бусдад битүүмжилсэн болон дуудлага худалдаагаар худалдсан тохиолдолд өмчлөх эрх шилжүүлэх гүйлгээг ТӨХ-ны тогтоол, мэдэгдэл, худалдах худалдан авах гэрээ, гүйлгээний шимтгэл төлсөн төлбөрийн баримтыг үндэслэн хийж гүйцэтгэнэ.

5.5 Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд нэмж гаргахдаа тэргүүн ээлжинд худалдан авах болон нэр зааж эзэмшүүлэх, өрийн хувьцаагаар солих тохиолдолд СЗХ-ны шийдвэр, тухайн компанийн нэр зааж эзэмшүүлэх жагсаалтыг албан тоот /нэр бүхий этгээдийн төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар, эзэмшүүлэх хувьцааны тоо ширхэг, үнийн дүн зэргийг тусгасан мэдээлэл/ бичгээр болон файлаар ирүүлсэн баримтуудыг үндэслэн гүйлгээг хийнэ.

5.6 Эрх бүхий байгууллагын шийдвэр, Шүүхийн шийдвэртэй эсхүл үл маргалдах журмаар үнэт цаас шилжүүлэх тухай холбогдох баримт (харилцагчийн хүсэлт, гэрээ дүгнэсэн акт, шүүхийн шийдвэр бүхий дагалдах материал) гүйлгээний шимтгэл төлсөн төлбөрийн баримтыг үндэслэн төвлөрсөн хадгаламжийн данс хооронд үнэт цаасны гүйлгээг хийнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.7 ҮЦК-ийн аж ахуйн нэгжийн данс, нөөцийн данснаас хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг барагдуулах тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шийдвэрийг, тухайн харилцагчийн өргөдөл, ҮЦК-ийн хүсэлт, үйлчилгээний шимтгэл төлсөн баримтыг үндэслэн гүйлгээг хийнэ.

5.8 Засгийн газрын хаалттай хэлбэрээр гаргасан засгийн газрын өрийн бичиг /ЗГӨБ/ Монгол банкны цахим арилжааны системээр хийгдэх бөгөөд өрийн бичиг худалдан авсан эзэмшигчийн мэдээллийг Монгол банк цахим системээр ирүүлснийг үндэслэн үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийг хөтөлж алба өмчлөх эрх шилжүүлэх гүйлгээ хийнэ.

5.9 Харилцагч ҮЦК-ийг өөрчилж, эзэмшиж буй үнэт цаасаа өөр ҮЦК-ийн болон кастодиан банкны тухайлсан дансанд өөрийн хүсэлтээр шилжүүлэх тохиолдолд тухайн данс эзэмшигчийн хүсэлт, үйлчилгээний хураамж төлсөн баримтыг тус тус үндэслэн үнэт цаасыг шилжүүлэх гүйлгээг хийнэ./Маягт-7/

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.10 Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь эзэмшиж буй үнэт цаасаа нэгтгэх, нийлүүлэх, хуваах замаар үнэт цаасны өмчлөх эрхээ шилжүүлэхэд хүсэлт гаргаж байгаа талаас албан хүсэлт болон шимтгэл төлсөн баримтыг хавсаргана.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

5.11 Иргэн болон ААН-ийн хүсэлтээр своп гүйлгээгээр өмчлөх эрх шилжүүлэх тохиолдолд талуудын албан хүсэлт /шилжүүлж буй үнэт цаасны тоо ширхэг, хугацааг тодорхой тусгасан байх/ гүйлгээний шимтгэл төлсөн баримтыг үндэслэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

5.12 Журмын 5.2, 5.3, 5.7-д заасан гүйлгээний шимтгэлийг тооцохдоо гүйлгээ хийх өдрөөс өмнөх тухайн үнэт цаасны арилжааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, хэрэв сүүлийн 52 долоо хоногт арилжаа хийгдээгүй бол тухайн үнэт цаасны нийт арилжааны *жигнэсэн* дундаж ханшийг тухайн гүйлгээгээр шилжүүлж буй үнэт цаасны тоонд үржүүлж тооцно.

5.13 Журмын 5.6, 5.10-д заасан гүйлгээний шимтгэлийг тооцохдоо эрх бүхий байгууллагаас шийдвэр гарсан өдрөөс өмнөх тухайн үнэт цаасны арилжааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, хэрэв сүүлийн 52 долоо хоногт арилжаа хийгдээгүй бол тухайн үнэт цаасны нийт арилжааны жигнэсэн дундаж ханшийг тухайн гүйлгээгээр шилжүүлж буй үнэт цаасны тоонд үржүүлж тооцно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.14 Журмын 5.8-д заасан гүйлгээний шимтгэлийг тооцохдоо анхдагч зах зээл дээр өмчлөх эрх шилжүүлэхэд худалдан авсан талаас, хоёрдогч зах зээл дээр өмчлөх эрх шилжүүлэхэд худалдсан болон худалдан авсан гүйлгээ тус бүрээс шимтгэл тооцно.

5.15 Журмын 5.9-т заасан гүйлгээний үйлчилгээний хөлсийг тооцохдоо тухайн данс эзэмшигчийн шилжүүлгийн гүйлгээ хийлгэх данс тус бүрээс тооцно.

Зургаа. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэл хангах

6.1 Үнэт цаас эзэмшигч нь өөрийн үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэл хангуулахаар зээлийн барьцаанд тусгаарлуулж болно. Энэхүү гүйлгээнд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1.1 дансны үлдэгдэл нь үүргийн гүйцэтгэл хангах үнэт цаасны нэр төрөл, тоо ширхэгтэй хүрэлцэхүйц байх;

6.1.2 тухайн гүйлгээ хийх хугацаанд уг үнэт цаас тусгаарлагдаагүй байна.

6.2 Үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхээ зээлийн барьцаанд тусгаарлуулахад доорхи баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

6.2.1 үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлт;

6.2.2 үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэл хангахыг зөвшөөрсөн тухай батламж /Маягт-2/-ыг 3 хувь үйлдэж, нотариатаар баталгаажуулсан байх;

6.2.3 Талуудын хооронд байгуулсан нотариатаар гэрчлүүлсэн зээлийн болон барьцааны гэрээ;

6.2.4 Гүйлгээний шимтгэл төлсөн баримт;

6.3 Журмын 6.2-т заасан баримт бүрдсэн тохиолдолд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг тусгаарлалтаас чөлөөлөх хүсэлт ирүүлэх хүртэл хугацаагаар түр тусгаарлан бүртгэнэ.

6.4 Үнэт цаасыг тусгаарлан бүртгэсэн болон тусгаарлалтаас чөлөөлсөн тухай мэдэгдлийг үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

6.5 Үүрэг гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд зээлийн барьцаанд тусгаарлагдсан үнэт цаасыг үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлт эсхүл гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үүрэг гүйцэтгэгчийн дансанд буцаан байршуулна.

6.6 Хэрэв үүрэг гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлийн барьцаанд тусгаарлагдсан үнэт цаасыг гэрээ дүгнэсэн акт эсхүл Шүүхийн шийдвэр зэргийг үндэслэн үүрэг гүйцэтгүүлэгчийн дансанд шилжүүлнэ. Гэрээ дүгнэсэн акт болон Шүүхийн шийдвэрт үнэт цаасны нэр, тоо ширхэг, үнэ ханш, шилжүүлэх данс, зэргийг тодорхой тусгасан байна.

6.7 Зээлийн барьцаанд тусгаарлуулах үнэт цаасны шимтгэлийг тооцохдоо барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс ирүүлсэн хүсэлтээс өмнөх арилжааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, нийт жигнэсэн дундаж ханшийн аль өндрөөр тооцно.

6.8 Тусгаарлалт дуусахаар заасан хугацаанд чөлөөлөх хүсэлт ирүүлээгүй тохиолдолд тусгаарлалтын хугацаа хэтэрсэн илүү хоног тутмыг тухайн тусгаарлагдсан үнэт цаасны 1 өдрийн шимтгэлээр тооцож чөлөөлнө.

6.9 Үүрэг гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас үнэт цаасыг үүрэг гүйцэтгүүлэгчийн дансанд шилжүүлэхдээ тухайн үнэт цаасыг шилжүүлэх өдрөөс өмнөх арилжааны

сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, нийт жигнэсэн дундаж ханшийн аль өндрөөр тооцно.

***Долоо. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх
үйл ажиллагааны үйлчилгээний хөлс***

7.1 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэхтэй холбоотой үйлчилгээний хөлсийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтооно.

***Найм. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх, гүйлгээ хийгдэх хугацаа***

8.1 Алба нь “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-иас ирүүлсэн баталгаажсан хэлцлийн мэдээг үндэслэн программын тусламжтайгаар үнэт цаасны өмчлөх эрхийг Т+3 хугацаанд шилжүүлнэ.

8.3 Журмын 5 дугаар бүлэгт заасан гүйлгээг харилцагчийн дансан дахь үнэт цаас чөлөөт үлдэгдэлтэй, гүйлгээ хийхтэй холбоотой шимтгэлийг төлсөн, анхан шатны баримтын бүрдэл хангасан тохиолдолд баримт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоног дотор хийж гүйцэтгэнэ.

8.4 Өмчлөх эрх бүртгэлийн шилжүүлгийн гүйлгээ, үүргийн гүйцэтгэл хангуулах болон бусад холбогдох гүйлгээний хураамж, шимтгэлийг харилцагчийн дансанд байршуулахдаа гүйлгээ хийх ажилтан нь Маягт-8-ийг бөглөж, Захиргаа санхүүгийн албанд хүлээлгэн өгнө.

Ес. Тайлан мэдээ

9.1 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэх үйл ажиллагааны тайланг гүйлгээ хийгдсэн өдөр бүр гаргана. Үүнд:

9.1.1 Тухайн өдрийн үнэт цаасны шилжүүлгийн жагсаалт /Маягт -3/

9.1.2 Бэлэглэлийн гэрээгээр шилжсэн үнэт цаасны дэлгэрэнгүй мэдээ;

9.1.3 Бэлэглэлийн гэрээгээршилжсэн үнэт цаасны хураангуй мэдээ;

9.2 Хороонд тогтмол гаргадаг мэдээ, тайланг холбогдох журмын дагуу гаргана.

9.3 Үнэт цаас эзэмшлийн тодорхойлолт /Маягт-4/ харилцагчийн дансан дахь үнэт цаасыг нэр төрөл, тоо ширхэгээр, тодорхой өдрөөр тасалбар болгон харилцагчийн регистерийн дугаартай тодорхойлолтыг тухайн харилцагчийн хүсэлтээр гаргана.

9.4 Алба нь харилцагч болон эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу дараах мэдээ, мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:

9.4.1 Дансны үлдэгдэл–Харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн данс дахь үнэт цаасны үлдэгдэл /Маягт-5/

9.4.2 Дансны гүйлгээний хуулга–Тодорхой хугацаанд харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн дансанд хийгдсэн үнэт цаасны гүйлгээний мэдээ /Маягт -6/;

9.4.3 Бусад зөвшөөрөгдсөн, боловсруулалт хийгдсэн мэдээ, мэдээлэл – компанийн “Нууцын тухай журам” –д заасан мэдээллийг гаргаж өгнө.

Арав. Хадгалалт, нууцлалт

10.1 Албанаас гарах мэдээ, тайлан, судалгаа нь албаны даргаар хянагдаж, баталгаажигдсан байна.

10.2 Арилжааны бус гүйлгээгээр бусдад үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжсэн тухай холбогдох бичиг баримтыг хариуцсан ажилтан нь дугаарлан өөрийн цоож, лац бүхий сейф,

шүүгээнд хадгалах бөгөөд “Нууцын тухай журам”-ын дагуу архивын хэмжээнд хавтаслаж, архивт шилжүүлнэ.

10.3 Албаны мэдээ, мэдээллийн хадгалалт, нууцлалтыг компанийн нууцын тухай журам, мэдээллийн аюулгүй байдлын журмаар тус тус зохицуулна.

Арван нэг. Хариуцлага

11.1 Энэхүү журмыг зөрчсөн ажилтан хариуцлагыг бүрэн хүлээх ба Гүйцэтгэх захирлын тушаалаар компанийн Дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

11.2 Энэхүү журмыг зөрчсөн үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар хорооны хянан шалгагч захиргааны шийтгэл ногдуулна.

11.3 Ханшийн өөрчлөлтөөс болж харилцагч болон бусдад учирсан хохирол, түүнчлэн шимтгэлийн мөнгийг байршуулаагүйн улмаас гүйлгээ хийгдээгүй тохиолдолд үүссэн хохирлыг компани хариуцахгүй.

11.4 Гүйлгээ хариуцсан ажилтан баримтын бүрдэл, хадгалалт, нууцлалтыг бүрэн хариуцна.

Арван хоёр.

12.1 Энэхүү журамд компанийн ТУЗ-ийн хурлын тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 1 дүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

Төрөл	Үйлчилгээний хөлс
ХОЭБ-ийн дансны баталгаажуулалт	500 төгрөг
Шинэ данс – Иргэн	2 000 төгрөг
Шинэ данс - Хуулийн этгээд	20 000 төгрөг
Данс нэгтгэх /өв залгамжлал болон компанийн хүсэлтээр данс нэгтгэхээс бусад тохиолдолд/	500 төгрөг
ЗГӨБ-ны анхдагч зах зээлд өмчлөх эрх шилжүүлэх /Монгол банкаар арилжаалсан/	Худалдан авсан талаас 2500 төгрөг
ЗГӨБ-ны хоёрдогч зах зээлд өмчлөх эрх шилжүүлэх /Монгол банкаар арилжаалсан/	Худалдсан болон худалдан авсан гүйлгээ тус бүрээс 2500 төгрөг
Харилцагч ҮЦК-ийг өөрчилж эзэмшиж буй үнэт цаасаа өөр ҮЦК, кастодиан банкны тухайлсан дансандаа шилжүүлэх	2500 төгрөг

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 2 дугаар хавсралт

Арилжааны бус гүйлгээний үнийн дүнгээс

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний хөлс
Шүүхийн шийдвэрийн дагуу үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бусдад шилжсэнийг бүртгэх	Нэхэмжлэгч талаас 0.2 хувь
Эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бусдад шилжсэнийг бүртгэх	
Гэрээ дүгнэсэн актын дагуу үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бусдад шилжсэнийг бүртгэх	Журмын 7-р хавсралтын дагуу
Зээлийн барьцаанд хувьцаа тусгаарлуулсан хоног тутамд	Зээлдэгч талаас /журмын 6-р хавсралтын дагуу/
Компани шинээр болон нэмж гаргасан хувьцааг, өрийг хувьцаагаар солиход нэр зааж эзэмшүүлэх	Эзэмшсэн талаас 0.1 хувь
Өмч хувьчлалын хүрээнд Төрийн өмчийн дуудлага худалдаагаар арилжигдсан хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлэхдээ үнийн дүнгээс	Худалдан авсан талаас 0.1 хувь
ҮЦК-ийн аж ахуйн нэгжийн болон нөөцийн данснаас үнэт цаас шилжүүлэх	Шилжүүлэгч талаас 3 хувь
Своп гүйлгээгээр өмчлөх эрх шилжүүлсэн хоног тутамд	Журмын 6-р хавсралтын дагуу

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 3 дугаар хавсралт

Өв залгамжлалын гүйлгээний үйлчилгээний хөлс

Д/д	Гүйлгээний төрөл	Үйлчилгээний хөлс /үнийн дүнгээс/
1	Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр худалдан авсан үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг өв залгамжлал болон гэрээслэлээр хүлээн авах тохиолдолд	1 хувь
2	Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээс бусад тохиолдолдлоор шилжүүлж авсан үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг өв залгамжлал болон гэрээслэлээр хүлээн авах тохиолдолд	3 хувь
3	Өвлүүлэгчийн дансанд байршсан ногдол ашиг, ногдол хувийн мөнгө, үнэт цаас борлуулсан бэлэн мөнгийг өвлөх болон гэрээслэх тохиолдолд үнийн дүнгээс	1 хувь

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 4 дүгээр хавсралт

Бэлэглэлийн гүйлгээний үйлчилгээний хөлс

Д/д	Гүйлгээний төрөл	Үйлчилгээний хөлс /үнийн дүнгээс/
1	СЗХ-ны 2007.11.12-ны 162 тоот тогтоолын хавсралт журмын 2.2-т заасан иргэнд бэлэглэх тохиолдолд	Бэлэглэгч талаас -5 хувь Бэлэг хүлээн авагч талаас-5 хувь
2	СЗХ-ны 2007.11.12-ны 162 тоот тогтоолын хавсралт журмын 2.3-т заасан иргэн хуулийн этгээдэд бэлэглэх тохиолдолд	Бэлэглэгч талаас – 10 хувь Бэлэг хүлээн авагч талаас -10 хувь
3	СЗХ-ны 2007.11.12-ны 162 тоот тогтоолын хавсралт журмын 2.5-д заасан иргэн, хуулийн этгээдэд бэлэглэх тохиолдолд	Бэлэглэгч талаас – 5 хувь Бэлэг хүлээн авагч талаас – 10 хувь

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 5 дугаар хавсралт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

/Эрх бүхий байгууллагын хүсэлтээр гаргасан мэдээ, мэдээлэл үнэ төлбөргүй/

Дансны үлдэгдэл	Хэвлэмэлээр – 500 төг
Дансны гүйлгээний хуулга	1 хуудас нь 500 төг
Бусад зөвшөөрөгдсөн, боловсруулалт хийгдсэн мэдээ мэдээлэл	1 хуудас нь 1 000 төг
5-аас дээш хувийн мэдүүлэг	1 000 төг
Үнэт цаас эзэмшлийн тодорхойлолт	ХОЭБ-ийн санд бүртгэлтэй харилцагчийн тодорхойлолт – 1 000 төг Төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй харилцагчийн тодорхойлолт Монгол хэл дээр-5 000₮, Англи хэл дээр- 10 000₮

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралт

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 6 дугаар хавсралт

ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ШИМТГЭЛ

50 сая хүртэл төгрөг	0.001 хувь
50 саяас 100 сая хүртэл төгрөг	Суурь 500 төгрөг дээр 50 саяас давсан дүнгийн 0.0009 хувиар
100 саяас 150 сая хүртэл төгрөг	Суурь 950 төгрөг дээр 100 саяас давсан үнийн дүнгийн 0.0008 хувиар
150 саяас 200 сая хүртэл төгрөг	Суурь 1 350 төгрөг дээр 150 саяас давсан үнийн дүнгийн 0.0007 хувиар
200 саяас 250 сая хүртэл төгрөг	Суурь 1 700 төгрөг дээр 200 саяас давсан үнийн дүнгийн 0.0006 хувиар
250 саяас 300 сая хүртэл төгрөг	Суурь 2 000 төгрөг дээр 250 саяас давсан үнийн дүнгийн 0.0005 хувиар
300 саяас 350 сая хүртэл төгрөг	Суурь 2 250 төгрөг дээр 300 саяас давсан үнийн дүнгийн 0.0004 хувиар
350 саяас 400 сая хүртэл төгрөг	Суурь 2 450 төгрөг дээр 350 саяас давсан үнийн дүнгийн 0.0003 хувиар
400 саяас 450 сая хүртэл төгрөг	Суурь 2 600 төгрөг дээр 400 саяас давсан үнийн дүнгийн 0.0002 хувиар
450 саяас 500 сая хүртэл төгрөг	Суурь 2 700 төгрөг дээр 450 саяас давсан үнийн дүнгийн 0.0001 хувиар
500 саяас 550 сая хүртэл төгрөг	Суурь 2 750 төгрөг дээр 500 саяас давсан үнийн дүнгийн 0.00009 хувиар
550 саяас 600 сая хүртэл төгрөг	Суурь 2 795 төгрөг дээр 550 саяас давсан үнийн дүнгийн 0.00008 хувиар
600 саяас 650 сая хүртэл төгрөг	Суурь 2 835 төгрөг дээр 600 саяас давсан үнийн дүнгийн 0.00007 хувиар
650 саяас 700 сая хүртэл төгрөг	Суурь 2 870 төгрөг дээр 650 саяас давсан үнийн дүнгийн 0.00006 хувиар
700 саяас 750 сая хүртэл төгрөг	Суурь 2 900 төгрөг дээр 700 саяас давсан үнийн дүнгийн 0.00005 хувиар
750 саяас 800 сая хүртэл төгрөг	Суурь 2 925 төгрөг дээр 750 саяас давсан үнийн дүнгийн 0.00004 хувиар
800 саяас 850 сая төгрөг хүртэл	Суурь 2 945 төгрөг дээр 800 саяас давсан үнийн дүнгийн 0.00003 хувиар
850 саяас 900 сая хүртэл төгрөг	Суурь 2 960 төгрөг дээр 850 саяас давсан үнийн дүнгийн 0.00002 хувиар
900 саяас 950 сая хүртэл төгрөг	Суурь 2 970 төгрөг дээр 900 саяас давсан үнийн дүнгийн 0.00001 хувиар
950 саяас 1 тэрбум хүртэл төгрөг	Суурь 2 975 төгрөг дээр 950 саяас давсан үнийн дүнгийн 0.000009 хувиар
1 тэрбум төгрөгөөс дээш	Суурь 2 980 төгрөг дээр 1тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнгийн 0.000008 хувиар

**ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТААР ӨМЧЛӨХ ЭРХ БУСДАД
ШИЛЖҮҮЛЭХ ТОХИОЛДОЛД ТООЦОХ ШИМТГЭЛ**

50 сая хүртэл төгрөг	5 хувь
50 саяас 100 сая хүртэл төгрөг	Суурь 2 500 000 төг дээр 50 саяас давсан дүнгийн 4.5 хувиар
100 саяас 150 сая хүртэл төгрөг	Суурь 4 750 000 төг дээр 100 саяас давсан үнийн дүнгийн 4 хувиар
150 саяас 200 сая хүртэл төгрөг	Суурь 6 750 000 төг дээр 150 саяас давсан үнийн дүнгийн 3.5 хувиар
200 саяас 250 сая хүртэл төгрөг	Суурь 8 500 000 төг дэр 200 саяас давсан үнийн дүнгийн 3 хувиар
250 саяас 300 сая хүртэл төгрөг	Суурь 10 000 000 төг дээр 250 саяас давсан үнийн дүнгийн 2.5 хувиар
300 саяас 350 сая хүртэл төгрөг	Суурь 11 250 000 төг дээр 300 саяас давсан үнийн дүнгийн 2 хувиар
350 саяас 400 сая хүртэл төгрөг	Суурь 12 250 000 төг дээр 350 саяас давсан үнийн дүнгийн 1.5 хувиар
400 саяас 450 сая хүртэл төгрөг	Суурь 13 000 000 төг дээр 400 саяас давсан үнийн дүнгийн 1 хувиар
450 саяас 500 сая хүртэл төгрөг	Суурь 13 500 000 төг дээр 450 саяас давсан үнийн дүнгийн 0.9 хувиар
500 саяас 550 сая хүртэл төгрөг	Суурь 13 950 000 төг дээр 500 саяас давсан үнийн дүнгийн 0.8 хувиар
550 саяас 600 сая хүртэл төгрөг	Суурь 14 350 000 төг дээр 550 саяас давсан үнийн дүнгийн 0.7 хувиар
600 саяас 650 сая хүртэл төгрөг	Суурь 14 700 000 төг дээр 600 саяас давсан үнийн дүнгийн 0.6 хувиар
650 саяас 700 сая хүртэл төгрөг	Суурь 15 000 000 төг дээр 650 саяас давсан үнийн дүнгийн 0.5 хувиар
700 саяас 800 сая хүртэл төгрөг	Суурь 15 250 000 төг дээр 700 саяас давсан үнийн дүнгийн 0.4 хувиар
800саяас 900 сая хүртэл төгрөг	Суурь 15 650 000 төг дээр 750 саяас давсан үнийн дүнгийн 0.3 хувиар
900 саяас 1 тэрбум төгрөг хүртэл	Суурь 15 950 000 төг дээр 800 саяас давсан үнийн дүнгийн 0.2 хувиар
1 тэрбум төгрөгөөс дээш	Суурь 16 150 000 төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнгийн 0.1 хувиар

“ҮЦТХТ” ХХК –ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг
бүртгэх үйл ажиллагааны журмын 8 дугаар хавсралт

ХХК нэгдэж нийлэх, хуваах замаар өмчлөх эрх шилжүүлэх шимтгэл

Үнийн дүн	Хувь, хэмжээ
100 сая хүртэл төгрөг	0.71 хувь
100 саяас 1 тэрбум хүртэл төгрөг	0.38 хувь
1 тэрбумаас 10 тэрбум хүртэл төгрөг	0.09 хувь
10 тэрбумаас 30 тэрбум хүртэл төгрөг	0.058 хувь
30 тэрбумаас 100 тэрбум хүртэл төгрөг	0.027 хувь
100 тэрбум төгрөгөөс дээш	35,100,000 төгрөг

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

ХАРИЛЦАГЧ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ДАНС НЭЭЛГЭХ ГЭРЭЭ

Дугаар

... оны ... сарын ... -ны өдөр

хот /аймаг

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” /“ҮЦТХТ”/ ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид данс нээх, мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой харилцаанд “ҮЦТХТ” ХХК-ийг төлөөлж ҮЦК, харилцагч овогтой нар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Харилцагчийн эрх, үүрэг

- 2.1 Төвлөрсөн хадгаламжийн данс нээлгэхдээ шаардлагатай мэдээллийг үнэн зөв, гаргацтай, цэвэр бичнэ.
 2.2 Төвлөрсөн хадгаламжид нэг үндсэн данстай, холболтын хэд хэдэн данстай байж болно.
 2.3 Төвлөрсөн хадгаламжийн дансыг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох, өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх эрхтэй.
 2.4 Харилцагч төвлөрсөн хадгаламжийн данс нээлгэх хураамж болон арилжааны гүйлгээний шимтгэл, үйлчилгээний хөлсийг саадгүй төлнө.
 2.5 Дансны гүйлгээг шалгаж, өөрийн гарын үсгээр баталгаажсан баримтаар гүйлгээ хийнэ.
 2.6 Харилцагч өөрийн гарын үсгийн баталгааг ҮЦТХТ-д өөрийн биеэр ирж гаргаж өгч болно. Эсхүл ҮЦК - иар дамжуулан гаргаж өгч болох ба энэ тохиолдолд заавал нотариатаар гэрчлүүлсэн байна.
 2.7 Өөрийн гарын үсгээр баталгаажсан аливаа захиалгаас үүдэн бий болох алдагдлыг бүрэн хариуцна.
 2.8 Төвлөрсөн хадгаламжийн дансны ерөнхий мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр “ҮЦТХТ” ХХК, ҮЦК-д мэдэгдэж зохих өөрчлөлтийг оруулна.

Гурав. ҮЦК-ийн эрх үүрэг

- 3.1 СЗХ-ны 2008 оны 223 дугаар тогтоолын хавсралт “Үнэт цаасны компанийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж, харилцагчийн дансанд хийгдэх гүйлгээний нууцыг хадгалж, гүйлгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийлгүүлнэ.
 3.2 Харилцагчийн захиалгаар хийгдэх гүйлгээг бичгээр, дуу хоолойны болон дүрст бичлэгээр баталгаажуулан өгсөн захиалгыг үндэслэн хийнэ.
 3.3 Хадгаламжийн дансанд гүйлгээ хийгдсэний дараа зөвхөн харилцагчийн хүсэлтээр дансны хуулгыг компаниас авч өгнө.
 3.4 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас харилцагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.
 Харилцах утасны дугаар

Дөрөв. “ҮЦТХТ” ХХК-ийн эрх, үүрэг

- 4.1 Харилцагчийн хадгаламжийн дансны нууцыг хадгалж, гүйлгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийнэ.
 4.2 Хадгаламжийн данс, өөрийн үйлчилгээ, шимтгэлтэй холбоотой журам, дүрмийн өөрчлөлтийг олон нийтэд ажлын 5 хоногт багтаан мэдээнэ.
 4.3 Хадгаламжийн дансанд гүйлгээ хийгдсэний дараа зөвхөн харилцагчийн хүсэлтээр өөрт нь болон зуучлагч ҮЦК-иар дамжуулан дансны хуулгыг өгнө.
 Харилцах утасны дугаар:
 ҮЦК-ийн утасны дугаар.....

ҮЦК дахь харилцагчийн дансны дугаар: №

Шимтгэл....%

Гэрээ байгуулсан:

“ҮЦТХТ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛХАРИЛЦАГЧ
/НЭР/ҮЦК-ИЙН
.....

.....

ИРГЭН ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ДАНС НЭЭЛГЭХГЭРЭЭ
/CLIENT ACCOUNT OPENING AGREEMENT AT THE CENTRAL DEPOSITORY/

. . . . оны . . . сарын . . . -ны өдөр /Date/

Дансны дугаар /Prefix/

Харилцагчийн төрөл /Suffix/

- ☐ Дотоодын иргэн /local individual / ☐ Дотоодын насанд хүрээгүй хүүхэд /local junior/
☐ Гадаадын иргэн /foreign individual/ ☐ Гадаадын насанд хүрээгүй иргэн /foreign junior /

Овог /Surname/.....

Нэр /Given name/.....

Улсын харьяалал /Country of Residence/ Хүйс /Gender/ эр /Man/ ☐ эм /Female/ ☐

Иргэний үнэмлэхийн дугаар /Passport or ID number/

Регистрийн дугаар /Registration number/

Эрхэлсэн ажил /Occupation/

Утас /Phone/:

Оршин суугаа байнгын хаяг /Permanent address/ Утас /Phone/:

Цахим хаяг /E-mail address/
.....

Ногдол ашиг хүлээн авах хэлбэр /Dividend disposal type/ Банк /Bank ☐ Бэлэн мөнгө /Cash ☐

Харилцах банкны дансны дугаар /Bank account number/ Шимтгэл /Fee/:

Данс эзэмшигчийн эзэмшилд буй үнэт цаас /Current securities holdings /:

№	Үнэт цаас /Securities/	Тоо ширхэг /Quantity/	№	Үнэт цаас /Securities/	Тоо ширхэг /Quantity/
1.			6.		
2.			7.		
3.			8.		
4.			9.		

“ҮЦТХТ” ХХК-ийн ХӨЭБКА-ны ажилтан /Staff signature of Depository and

Registration of Ownership Rights and Custodian Department, MCSD/

“ҮЦТХТ” ХХК-ийн ХӨЭБКА-ны дарга /Head of Depository and Registration of

Ownership Rights and Custodian Department, MCSD/

Харилцагч /Client signature/

ҮЦК-ийн ажилтан /Staff at Securities Firm/

ҮЦК-ийн захирал /Director of Securities Firm/

ХУУЛИЙН ЭТГЭЭД ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИНД ДАНС НЭЭЛГЭХ ГЭРЭЭ
/ENTITY ACCOUNT OPENING AGREEMENT AT THE CENTRAL DEPOSITORY/

. оны . . . сарын . . . -ны өдөр /Date/

Дансны дугаар /Prefix/

Харилцагчийн төрөл /Suffix/

☐ Дотоодын ААН /Local company ☐ /Гадаадын ААН /Foreign company

Оноосон нэр /Company name/

Улсын бүртгэлийн дугаар /Company ID/

Регистрийн дугаар /Registration ID/

Үүсгэн байгуулагдсан огноо /Incorporation/

Оршин байгаа байнгын хаяг /Entity Address/ Утас /Phone/

Факс Fax

ДАНС ЗАХИРАН ЗАРЦУУЛАГЧ

Данс захиран зарцуулагчийн нэр /Individual name/

Овог /Surname/

Нэр /Given name/

Улсын харъяалал /Country of residence/

Иргэний үнэмлэхийн дугаар /Passport or ID number/

Регистрийн дугаар /Registration number/

Эрхэлсэн ажил /Occupation/ Утас /Phone/

Захиран зарцуулагчийн гарын үсэг /Тамга тэмдэг/

Шимтгэл /Fee/

Trustee signature /Stamp/

“ҮЦТХТ” ХХК-ийн ХӨЭБКА-ны ажилтан /Staff signature of Depository and

Registration of Ownership Rights and Custodian Department, MCSD/

“ҮЦТХТ” ХХК-ийн ХӨЭБКА-ны дарга /Head of Depository and Registration of

Ownership Rights and Custodian Department, MCSD/

ҮЦК-ийн ажилтан /Staff at Securities Firm/

ҮЦК-ийн захирал /Director of Securities Firm/

Хуулийн этгээд бол данс нээлгэх тухай өргөдөл, Улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний баталгаатай хуулбар, данс дахь мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг захиран зарцуулах албан тушаалтны овог нэр, төлбөр тооцооны баримтад зурах гарын үсгийн маяг /Гарын үсгийн маяг нь нотариатын баталгаатай байна/ тамга, тэмдгийн дараасыг хавсаргана.

ЖИЧ: Дээрх үзүүлэлтүүдийг заавал үнэн зөв, бүрэн бөглөсөн байх ёстойг анхаарна уу

**Үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэл
хангахыг зөвшөөрсөн тухай батламж №**

Үүргийн гүйцэтгэлийн төрөл

“ҮЦТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэлийг хангахаар харилцан тохиролцож гэрээ байгуулсан тухай батламж гаргаж байна.

Дор дурьдсан харилцагчийн дараах үнэт цаасны гүйлгээг батламж гаргасан өдрөөс эхлэн 200.. он .. сар .. өдрийг хүртэл ... хоногийн хугацаагаар тусгаарлаж хадгалахыг хүсье.

Дд	Харилцагч нэр	Данс дугаар	Хувьцааны нэр,төрөл	Тоо,ширхэг

/ тоогоор, үсгээр бичих /

.....
.....

БАТЛАМЖ ГАРГАСАН:

Үүрэг гүйцэтгэгч:
Овог нэр:
Регистрийн дугаар:
Дансны дугаар:

Гарын үсэг

20. . он. . .сар. . .өдөр

Үүрэг гүйцэтгүүлэгч:
Овог нэр:
Регистрийн дугаар:
Дансны дугаар:

Гарын үсэг

Нотариатын батламж

Батламжийг хүлээн авч гүйлгээ хийсэн: ХӨЭБКА-ны ажилтан.....

20. . он. . .сар. . .өдөр

..... өдрийн үнэт цаасны шилжүүлгийн жагсаалт

Д/д	Шилжүүлэгч		Код	Ширхэг	Хүлээн авагч		Код
	Дансны дугаар	Овог нэр			Дансны дугаар	Овог нэр	

Дүн

Тайлан гаргасан: ХӨЭБКА-ны ажилтан

/

/

Тайлан хянасан: ХӨЭБКА-ны дарга

/

/

Маягт-4

Үнэт цаас эзэмшлийн тодорхойлолт №

ҮЦТХТ-ийн төвлөрсөн хадгаламжинд 20 .. он .. сар .. өдрийн байдлаар нэр бүхий харилцагчид дараах үнэт цаас эзэмшиж буйг тодорхойлов.

д/д	Харилцагч нэр	Данс дугаар	Хувьцааны нэр, төрөл	Тоо, ширхэг
1				

ХӨЭБКА-ны дарга:

/

/

Маягт-5

“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК

Харилцагчийн дансны үлдэгдэл

Огноо

Харилцах утас:

Данс

Овог

Нэр

Регистер.....

Үнэт цаасны нэр /код/

Эхний үлдэгдэл

Дебит

Кредит Эцсийн үлдэгдэл

Хуулга гаргасан:

/...../

“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК

Харилцах

утас:

Харилцагчийн дансны дэлгэрэнгүй хуулга

Хуулганд хамрагдсан
хугацаа:

/огноо/

Дансны дугаар:

Овог нэр:

Регистр:

Огноо	Данс	Үнэт цаас	Дебит	Кредит	Үнэ
Шимтгэл		Тайлбар			
.....					

Эхний	Дебит	Үнэт цаас	Кредит	Эцсийн
				

Орлого	Зарлага Бэлнээр мөнгөний утга
--------	-------------------------------

Зузаатга
л
Дансны
зарлага
д
Данс хооронд
орлого/зарлага ҮЦ
шилжүүлсний зарлага
үнэт цаас авахад /
шимтгэлд Үнэт цаас
зарахад / шимтгэлд
Арилжааны шимтгэлд / биржийн шимтгэлд

Хуулга гаргасан: /...../

Хуулга хянасан: /...../

ҮНЭТ ЦААС ШИЛЖҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

“ҮЦТХТ” ХХК-д

.....овогтой.....биҮЦК-ийн.....тоот данс дахь доорхи үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжийн төвд нээлгэсэнҮЦК-ийн тоот дансандаа шилжүүлэх хүсэлтэй байгаа тул өргөдлийн дагуу үнэт цаасны шилжүүлгийн гүйлгээ хийж өгнө үү.

1. Prefix.....

д/д	ҮЦ-ны код	Үнэт цаасны нэр	Тоо

2. Бүгдийг сонгох ☐

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн/

Өргөдөл гаргасан::...../...../

Гэрийн хаяг:.....

Утас:

Гүйлгээ хийсэн: ХӨЭБКА-ны ажилтан/ /

Хянасан: ХӨЭБКА-ны дарга...../...../

20.. оны сарын өдөр

Баримт хүлээн авсан:

..... Тооцсон хураамж:

.....

/ Иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана уу /

Маягт-8

**Өмчлөх эрх бүртгэлийн шилжүүлгийн гүйлгээ, үүргийн гүйцэтгэл
хангуулах болон бусад холбогдох гүйлгээний хураамж, шимтгэлийг
харилцагчийн дансанд байршуулах**

Д/д	Гүйлгээний утга	Төлбөр байршуулах төвлөрсөн хадгаламжийн дансны дугаар	Данс эзэмшигчийн овог, нэр	Үнийн дүн	Тайлбар
1					

Тамга

Албаны дарга : /

Албаны ажилтан:...../

Жич: ХӨЭБКА-ны дарга, гүйлгээ хариуцсан мэргэжилтэн гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна. .

БАТЛАВ
“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ
“
ЗАХИРАЛ

ҮЦК” ХХК-ИЙН

/ /

20.. оны ...-р сарын ...-ны өдөр

№

Улаанбаатар хот

Цахим үйлчилгээний гэрээ

Энэхүү гэрээг нэг талаас “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид ҮЦТХТ гэх/, нөгөө талаас “..... ҮЦК” ХХК /цаашид ҮЦК гэх/ бид /хамтад нь талууд гэх/ Монгол улсын “Иргэний тухай” хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль болон бусад холбогдох хууль, “ҮЦТХТ” ХХК-ийн холбогдох журмыг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр талуудын эрх, үүргийг тогтоох, харилцагч иргэдийн төвлөрсөн хадгаламжийн данс нээхэд зарцуулах цаг хугацааг хэмнэж, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор ҮЦК-иас төвлөрсөн хадгаламжид данс нээх баримтын мэдээллийг ҮЦТХТ-ийн цахим системд холбогдон, цахим сүлжээгээр дамжуулан хүргүүлж, төвлөрсөн хадгаламжийн данс нээхэд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээгээр зөвхөн Монгол улсын иргэдийн төвлөрсөн хадгаламжид данс нээх харилцааг зохицуулна.

Хоёр. Үндсэн нөхцөл

- 2.1 ҮЦК нь харилцагчтай байгуулсан төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээний мэдээллийг цахим системд холбогдож зөвхөн файл хэлбэрээр бүрдүүлж, баталгаажуулан ҮЦТХТ-д ирүүлнэ.
- 2.2 Харилцагчтай байгуулсан “Төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ” болох анхан шатны баримтыг ҮЦК нь өөр дээрээ баримтжуулан хадгална.

Гурав. ҮЦТХТ-ийн эрх, үүрэг

3.1 ҮЦТХТ нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 3.1.1 ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмыг баримтлан ажиллах;
- 3.1.2 ҮЦК-ийн цахим системд нэвтрэх нэр, нууц үг зэргийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;
- 3.1.3 Өөрийн үйлчилгээ, шимтгэлтэй холбоотой журмын өөрчлөлтийг олон нийтэд ажлын 5 хоногт багтаан өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх;
- 3.1.4 Цахим системээр мэдээллийг хүлээн авах боломжгүй болсон нөхцөлд нөгөө талдаа ажлын 1 хоногийн дотор мэдэгдэх;
- 3.1.5 Мэдээллийг хүлээн авахад шаардлага хангахуйц хүчин чадалтай компьютер техник хэрэгсэл, тог баригч, вирусээс хамгаалах шаардлага хангасан програм суулгаж, найдвартай сүлжээг хангаж ажиллах;
- 3.1.6 Хүлээн авч буй мэдээллийн аюулгүй, эрсдэлгүй, халдлагад өртөхгүй байх бүрэн бүтэн байдлыг хангах;

3.2 ҮЦТХТ нь дараах эрхтэй. Үүнд:

3.2.1 ҮЦТХТ нь ҮЦК-иас цахимаар ирүүлсэн “Төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ”-ний мэдээлэл болон бусад мэдээллийг хүлээн авч хянан, ҮЦК-ийн мэдээлэл болон УБЕГ-аас ирүүлсэн мэдээллийн сантай тулган, тохирсон тохиолдолд ажлын гурав хоногт дансыг нээх буюу баримт бичгүүд шаардлага хангаагүй, мэдээлэл зөрсөн бол данс нээхээс татгалзах эрхтэй;

3.2.2 Харилцагчийн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэх гэрээ байгуулсан эсэхийг шаардлагатай тохиолдолд баталгаажуулан анхан шатны баримтыг шаардах, баримтын бүрдүүлбэрийг шалгах;

3.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах;

Дөрөв. ҮЦК-ийн эрх, үүрэг

4.1 ҮЦК нь дараах үүргийг хүлээнэ.

4.1.1 Харилцагчийн харилцах данс болон төвлөрсөн хадгаламжийн дансны талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;

4.1.2 Цахим системд нэвтрэх нэр болон нууц үгийг бусдад дамжуулахгүй байх бөгөөд нууцлалын бүрэн бүтэн байдлыг бие даан хариуцах;

4.1.3 Харилцагчийн “Төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ” болох анхан шатны баримтыг өөр дээрээ баримтжуулан хадгалах;

4.1.4 ҮЦК нь “Иргэн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэх гэрээ”-ний мэдээллийг баталгаажуулан ҮЦТХТ-д цахим системээр дамжуулан хүргүүлэх;

4.1.5 “Иргэн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэх гэрээ”-нд гарын үсэг зурах эрх бүхий /итгэмжлэгдсэн/ ажилтан, албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулах буюу ҮЦТХТ-ийн холбогдох журмыг дагаж мөрдөх;

4.1.6 Харилцагчийн хүсэлтийн дагуу төвлөрсөн хадгаламжийн данс нээх харилцааг зохих журмын дагуу бүрэн зохион байгуулж, энэхүү харилцаанаас үүдэлтэй эрсдэл, хариуцлагыг өөрөө хүлээнэ.

4.1.7 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас талуудад болон харилцагчид учирсан хохирлыг бүрэн хариуцах;

4.1.8 ҮЦК нь цахим системээр данс нээх мэдээлэл илгээх боломжгүй нөхцөлд нөгөө талдаа ажлын 1 хоногийн дотор мэдэгдэнэ.

4.1.9 Төвлөрсөн хадгаламжид данс нээлгэх шимтгэл хураамжийг холбогдох журмын дагуу саадгүй төлөх;

4.1.10 Мэдээллийг дамжуулахад шаардлага хангахуйц хүчин чадалтай компьютер техник хэрэгсэл, тог баригч, вирусээс хамгаалах шаардлага хангасан програм суулгаж, найдвартай сүлжээг хангаж ажиллах;

4.1.11 Өгч буй мэдээллийн аюулгүй, эрсдэлгүй, халдлагад өртөхгүй байх бүрэн бүтэн байдлыг хангах;

4.2 ҮЦК нь дараах эрх эдлэнэ.

4.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах эрхтэй.

Тав. Нэвтрэх нэр болон нууц үг олгох

5.1 Цахим системд нэвтрэх нэр болон нууц үгийг ҮЦТХТ-д бүртгүүлсэн цахим шуудангаар илгээнэ.

5.2 ҮЦК нь нэвтрэх нэр, нууц үгээ мартсан тохиолдолд ҮЦТХТ-д хандан дахин сэргээлгэж, цахим шуудангаар авна.

5.3 ҮЦК нь цахим нууц үг болон цахим шуудангийн мэдээллээ алдсан бол ҮЦТХТ-д нэн даруй мэдэгдэж эрхээ хаалгана.

5.4 ҮЦК нь ҮЦТХТ-д үйлчилгээний хөлс төлөлгүй ажлын 5 хоногоос хэтэрсэн тохиолдолд ҮЦК-ийн цахим системд нэвтрэх нэр болон нууц үгийг ҮЦТХТ хүчингүй болгох бөгөөд үйлчилгээний хөлсийг төлсөн даруйд ҮЦТХТ-д хандаж эрхээ сэргээлгэнэ.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1 Энэхүү гэрээ цуцлагдахаас өмнө цахим системээр дамжуулан ирүүлсэн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэх гэрээний эрх үүрэг нь биелэгдэж дуусах хүртэл хугацаанд гэрээний

зохицуулалт талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

6.2 ҮЦК-иас цахим системээр ирүүлсэн төвлөрсөн хадгаламжийн данс нээлгэх гэрээний мэдээлэл болон анхан шатны баримтын бүрдэл, бүрдлийн үнэн зөвийг ҮЦК бүрэн хариуцах бөгөөд уг гэрээний 4.1,5 дахь заалтыг хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх аливаа хариуцлагыг ҮЦТХТ хүлээхгүй.

6.3 Талууд мэдээллийн нууцыг чандлан хадгалах ба түүний нууцлал аюулгүй байдлыг дотооддоо хангах арга хэмжээг авна.

Долоо. Бусад

7.1 Гэрээний хугацаа талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаатай байх ба гэрээний хугацаа дуусахад талуудын аль нэг нь гэрээг цуцлах, дуусгавар болгох санал гаргаагүй тохиолдолд мөн хугацаагаар энэхүү гэрээнд заасан нөхцөлтэйгээр сунгагдсанд тооцно.

7.2 Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь гэрээг үргэлжлүүлэн дагаж мөрдөх боломжгүй болсон тохиолдолд нэг талын санаачилгаар энэхүү гэрээг цуцалж болно.

7.3 Гэрээний 7.2-т заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд энэ тухай нөгөө талдаа 7 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

7.4 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү гэрээний адил бичгээр үйлдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарсанаар хүчин төгөлдөр болно. Ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

7.5 Энэхүү гэрээтэй холбогдон талуудын дунд гарах маргааныг талууд тохиролцоонд хүрэх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол маргааныг Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан талууд:

“ҮЦТХТ” ХХК-ийг төлөөлж

“..... ҮЦК” ХХК-ийг төлөөлж

Мэдээлэл технологийн албаны дарга

.....

...../...../

...../...../

Хаяг: УБ хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо

Хаяг:

Самбуугийн гудамж 16-1

Утас: 70113671, 70120464

Утас:

Факс: 70114424

Факс:

И-мэйл:

И-мэйл:

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн./